

БАТЛАВ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ

Н ХҮРЭЛБААТАР

2022 оны 03 сарын 17 өдөр

**ИХ СУРГУУЛИУДЫН БАГШ, АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН ДУНД
ЗОХИОГДОХ СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2022 оны 03 сарын 15 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Их сургуулиудын хамтын үйл ажиллагааг бэхжүүлэх, багш, ажилтан, албан хаагчдын нарын эрүүл мэндийг дэмжих, спортоор хичээллэх сонирхлыг өрнүүлэх зорилготой.

Хоёр. Тэмцээн явуулах хугацаа, байр

2022 оны 3 дугаар сарын 26-27 -ний өдрүүдэд явагдана. Тэмцээн МУБИС-ийн Биеийн тамирын сургуулийн спорт зааланд явагдана.

Гурав. Тэмцээний төрөл

№	Спортын төрөл	Оролцох хүний тоо	Хугацаа	Цаг
1	Сагсан бөмбөг	10 эмэгтэй 10 эрэгтэй Дасгалжуулагч тус бүр нэг	3 сарын 26	9.00-21.00
2	Волейбол	10 эмэгтэй 10 эрэгтэй Дасгалжуулагч тус бүр нэг	3 сарын 27	9.00-21.00
3	Дартс	Удирдлагын баг 1 эрэгтэй, 1 эмэгтэй	3 сарын 26	12.00-15.00

Дөрөв. Багийн бүрэлдэхүүн

Тэмцээнд тухайн байгууллагын үндсэн багш, ажилтан оролцоно. Гэрээт багш ажилтан оролцохгүй.

Дартсын төрөлд сургуулийн захирал нь газрын дарга буюу түүнээс дээш албан тушаал бүхий тамирчинтай баг болж тоглоно.

Биеийн тамирын багш нар багийн тоглогчийн бүрэлдэхүүнд оролцохгүй, дасгалжуулагч, зохион байгуулагчийн үүрэгтэй тэмцээнд оролцоно.

Тав. Зохион байгуулалт

Оролцогч их сургуулиудын биеийн тамирын тэнхимүүд хамтран зохион байгуулна. Ерөнхий зохион байгуулагчаар АШУҮИС- АШУҮИС-ийн Био-Анагаахын сургуулийн Биеийн тамирын тэнхимийн эрхлэгч, Сагсан бөмбөгийн ОУХМ Б.Дашдэлгэр (Утас: 88085350) ажиллана.

Тэмцээний нээлтийн ажиллагаа 2022 оны 3 сарын 26-ны 11:00 цагт болно. Нээлтийн үйл ажиллагаанд баг тамирчид сургууль, байгууллагын туг, хаягийг барьж, тоглолтын хувцастай оролцоно.

Зургаа. Техникийн зөвлөгөөн, тэмцээн явагдах систем

Техникийн зөвлөгөөний хурал 2022 оны 3 дугаар сарын 21-нд 15:00 цагаас АШУҮИС-ийн Биеийн тамирын тэнхимийн багш нарын ерөөнд явагдана. Техникийн зөвлөгөөнд багийн ахлагч болон төлөөлөл багийн баталгаажуулсан мэдүүлэгтэй оролцоно. Багийн тооноос хамаарч техникийн зөвлөгөөн дээр тэмцээн явуулах системийг тохирно.

Долоо. Мэдүүлгийн заавар

Батлав. Сургуулийн захирал

Их сургуулиудын багш, ажилтан, албан хаагчдын дунд зохиогдох спортын тэмцээнд оролцох сургуулийн баг тамирчдын мэдүүлэг

Төрөл.

Дугаар	Овог нэр	Албан тушаал	Регистр	Хүйс	Үүрэг	Спортын зэрэг цол	Зураг

Багийн ахлагч: Утас:

Багийн дасгалжуулагч: Утас:

Найм. Оролцох багуудын эрхийн төлбөр

Тэмцээний эрхийн төлбөр 4,000,000 төгрөг (Дөрвөн сая) байна. Сагсан бөмбөг эрэгтэй эмэгтэй, волейбол эрэгтэй, эмэгтэй, дартсын багуудын эрх багтсан. Эрхийн төлбөрийг шүүгчийн цалин, тэмцээний шагнал, урамшуулалд зарцуулна. Төлбөр төлөх дансны мэдээллийг техникийн зөвлөгөөн дээр өгнө.

Ес. Тэмцээний шагнал, урамшуулал

Спортын төрөл тус бүрт (Сагсан бөмбөг эрэгтэй, эмэгтэй, волейбол эрэгтэй эмэгтэй, дартс холимог баг) 1,2,3 дугаар байр эзэлсэн багш тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Багийн нэгдсэн дүнг медалийн чанараар тооцон эхний гурван байрыг шалгаруулж I байрыг цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар, II, III байрыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.